



ТОСТ, ТОСОНБУМБЫН НУРУУНЫ БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(2021-2025)



ТОСТ, ТОСОНБУМБЫН НУРУУНЫ БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021-2025 ОН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БНГ	Байгалийн Нөөц Газар
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОАЖГ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар
БНХМН	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл
ГГСБЦГ	Говь Гурван Сайхны Байгалийн Цогцолборт Газар
ДЦИЭХХ	Дэлхийн Цоохор Ирвэсний Экосистемийг Хамгаалах Хөтөлбөр
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦГ	Дархан цаазат газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИХС ТББ	Ирвэс Хамгаалах Сан ТББ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал Аж Ахуй
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ОУИХС	Олон Улсын Ирвэс Хамгаалах Сан
ОУ	Олон Улс
ОНААН	Орон нутгийн аж ахуйн нэгж
ОБЗ	Орчны бүсийн зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
ТХГНУГ	Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Удирдлагын Газар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗ	Хамгаалалтын Захиргаа
ХМЗ	Хамтын Менежментийн Зөвлөл
ХАА	Хөдөө Аж Ахуй
ХЦ	Хилийн цэрэг



Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Тост, Тосонбумбын нурууг УИХ-ын 92 дугаар тогтоолоор 2016 онд “Байгалийн Нөөц” газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан билээ. Энэхүү шийдвэр нь Монгол Улсын Их Хурлаас 1992 онд нийт газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалттай статусын аль нэгэн хэлбэрт хамруулна гэсэн зорилгын дагуу хийгдсэн болно. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэгч ТХГН-ийн “Үндэсний хөтөлбөр” нь тус заалтыг хэрэгжүүлсэн төдийгүй дэлхийд ховордсон цоохор ирвэсний голомт нутгийг хамгаалалтанд авснаараа онцлог юм.

Хамгаалалтанд авсан үеэс тус БНГ-н менежментийн механизмыг бий болгоход аймгийн удирдлага анхаарал хандуулан дэмжиж ТХГ-ын захиргааны байр, мэргэжилтэн байгаль хамгаалагч нарын орон тоог батлан санхүүжүүлж ирлээ. Мөн БНГ-ын 2022-2025 оны менежментийн төлөвлөгөөг 2022 оны 6 сарын 10-ны аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэж 6/7-р тогтоолоор батласан нь тус БНГ-ын цаашдын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо. Тус төлөвлөгөөнд хамгаалах 5 үнэт зүйлсийг тодорхойлон тэднийг хамга-

алах зорилго чиглэлийг үнэлгээ мониторингийн төлөвлөгөөтэй нь хийж гүйцэтгэхдээ БОАЖЯ-наас чиглүүлсэн ТХГН-н менежментийн төлөвлөгөө боловсруулах арга зүйг ашигласан болно. Энэхүү төлөвлөгөөг нутгийн иргэд хамтрагч талуудын оролцоотойгоор Ирвэс Хамгаалах Сан ТББ-ын мэргэжилтнүүд Английн зэрлэг амьтан хамгаалах (Peoples Trust for Endangered Species-PTES) байгууллагын санхүүжилтээр боловсруулж, менежментэд оролцогч талуудын санал дээр үндэслэн шинжлэх ухааны мэдээллээр баталгаажуулсан нь үнэлгээ мониторинг хийхэд маш дөхөмтэй болсон гэж үзэж байна.

Монгол оронд төдийгүй дэлхийн хэмжээнд ховордсон цоохор ирвэс бол газрын доорх баялагаас ялгаагүй монгол орны байгалийн нандив өв. Энэ амьтны экологийн тэнцвэрт байдалд үзүүлэх ач холбогдол өндөр учраас Тост, Тосонбумбын Нурууны БНГ-н хамгааллын үйл ажиллагаа нэн чухал үүрэгтэйг энд цохон тэмдэглээд Өмнийн цэнхэр говийн хүрээлэн буй орчны хамгаалалд шинэлэг арга барилыг нэвтрүүлэхийг менежментэд оролцогч талуудад хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн
Аймгийн Засаг дарга

Р.Сэддорж

ТАЛАРХАЛ

Энэхүү менежментийн төлөвлөгөөг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Английн Нэн ховордсон амьтан хамгаалах иргэдийн нийгэмлэг (PTES)-ийн санхүүжилтээр Ирвэс Хамгаалах Сан боловсруулав.

Арга зүйн зөвлөлөгөө өгч ажилласан Олон Улсын Ирвэс Хамгаалах Сангийн шинжлэх ухааны багийн судлаач Др Жастин Шанти, Др Яаш Вийр, Др Густав Самелиус, Др Орьян Жоханссон болон ИХС-ын мэргэжилтнүүд, Дэ Нэйче Консерванси байгууллагын (TNC) Монгол дахь төлөөлөгчийн газрын мэргэжилтэн Э. Төгөлдөр, хамтран ажилласан Өмнөговь аймгийн БОАЖГ, ГГСБЦГ, Тост багийн ЗД ба Тост багийн иргэдэд талархлаа илэрхийлье.


ГАРЧИГ

ЖАГСААЛТ	6
1. ОРШИЛ	7
Хураангуй	8
1.1 Менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, хамрах хүрээ	8
1.2 Эрх зүйн таатай орчин, менежмент, хэрэгжилтийн механизм	8
2. ТАНИЛЦУУЛГА, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	9
2.1 Алсын хараа	10
2.2 Хамрах хүрээ	10
2.2.1 Нутаг дэвсгэр	10
2.2.2 Хугацаа	12
2.3 Зорилго	12
2.4 Хамгаалах үнэт зүйлс	12
2.4.1 Цоохор ирвэс (<i>Panthera uncia</i>)	12
2.4.2 Янгир ямаа (<i>Capria sibirica</i>)	15
2.4.3 Аргаль хонь (<i>Ovis ammon</i>)	16
2.4.4. Монгол буйлс (<i>Amygdalus Mongolica</i>)	17
2.4.5. Археологийн түүх соёлын дурсгалууд	18
2.5 Хамгаалах үнэт зүйлүүдийн төлөв байдлын үнэлгээ	19
2.6 Аюул дарамт	21
2.6.1 Бэлчээр, мал	21
2.6.2 Уур амьсгалын өөрчлөлт – ган, зуд	22
2.6.3 Усны хомсдол	23
2.6.4 Туруутан амьтадын бэлчээрийн хомсдол	24
2.6.5 Хуулийн хэрэгжилт хангалтгүй байдал	24
2.6.6 Ашигт малтмалын хайгуул ба олборлолт	25
2.7 Нөхцөл байдлын дүн шинжилгээ	25
2.8 Стратеги, зорилт	26
2.9 Үйл ажиллагааны төлөвлөгөө	28
3. МОНИТОРИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
4. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ	46
5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	46
5.1 Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын хамгаалалтын захиргааны бүтэц зохион байгуулалт	46
5.2 Төсөв санхүү, нөөц	46
6. ХАМТРАГЧ ТАЛУУД	46
6.1 Хамтрагч талуудад хийсэн дүн шинжилгээ	46

ЖАГСААЛТ

Газрын зураг 1. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын байршил	10
Газрын зураг 2. ДЦИЭХХ- ийн ландшафтууд	11
Газрын зураг 3. Тост, Тосонбумбын нурууны БНГ, бүсчлэл	11
Газрын зураг 4. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын ан амьтдын тархац	13
Газрын зураг 5. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын цоохор ирвэсийн амьдрах орчин	14
Газрын зураг 6. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын уст цэгүүд	23
Газрын зураг 7. Тост, Тосонбумбын нурууны БНГ-т сүүлийн 5 жилд намаржаа өвалжөөний газраа сэлгэлгүй ашигласан айлуудын тоо (n=82)	24
Зураг 1. Цоохор ирвэс	12
Зураг 2. Янгир	15
Зураг 3. Аргаль хонь	17
Зураг 4. Монгол буйлс	17
Зураг 5. Хадны сүг зураг	18
Хүснэгт 1. Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлыг үнэлэх шалгуурууд	19
Хүснэгт 2. Аюул дарамтын нийлбэр үнэлгээ	21
Хүснэгт 3. Тост багийн малын тоо толгой (ҮСХ 2019)	22
Хүснэгт 4. Үйл ажиллагааны стратеги, зорилтууд	27
Хүснэгт 5. Үйл ажиллагааны төлөвлөгөө	28
Хүснэгт 6. Мониторинг төлөвлөгөө	40
Хүснэгт 7. 2021-2025 онд Тост, Тосонбумбын БНГ-ын менежментийг хэрэгжүүлэхэд гарах төсөв	46
Хүснэгт 8. <i>БНГ-ын менежментэд оролцох талууд</i>	47
Диаграм 1. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын нөхцөл байдлын үнэлгээ	25
Диаграм 2. Үр дүнгийн гинжин хэлхээний диаграм	26

ОРШИЛ I



@ SLCF/SLT

Хураангуй

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг орших Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар (БНГ) нь 896,540.37 га талбай бүхий нутаг дэвсгэртэй. 2016 онд УИХ-ын 35 дугаар тогтоолоор цоохор ирвэс, түүний идэш тэжээл, тэдгээрийн амьдрах орчинг хамгаалах зорилгоор тус газар нутгийг байгалийн нөөц

газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтанд авсан. 2017 онд Засгийн Газрын 90/91 дүгээр тогтоолоор 733,058 га талбай бүхий БНГ-ын хилийн заагийг тогтоож, 2019 онд Засгийн газрын 319 дүгээр тогтоолоор хилийн заагийг өргөтгөсөн билээ. Тус БНГ-ын хамгаалалтын захиргаа нь Гурвантэс сумын төвд байрлана.

1.1 МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ

Менежментийн төлөвлөгөөний зорилго нь говийн экосистем, устаж болзошгүй ан амьтдын төрөл зүйл, цоохор ирвэс болон түүний идэш тэжээлийг шинжлэх ухааны үндэслэл, хамтын оролцооны арга зүйд тулгуурлан хамгаалахад оршино. Менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа, байгаль орчин аялал жуулчлалын яамны (БОАЖЯ) сайдын 2021 оны 1-р сарын 22-ны өдрийн А/16 тоот тушаалаар баталсан байгаль хамгааллын төлөвлөлтийн Нээлттэй Стандарт (Open standard) аргачлалыг удирдлага болгосон болно.

Менежментийн төлөвлөгөө нь Тост, Тосонбумбын нурууны БНГ-ыг удирдан зохицуулахад оролцогч талуудын ашиглах гол зөвлөмж, чиглэл бүхий баримт бичиг бөгөөд орон нутгийн, үндэсний, ОУ-ын нөөц бололцоо, санаачилгад тулгуурлан байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах, хамгаалах хамтын менежментийн төлөвлөгөө юм.

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь танилцуулга, нөхцөл байдлын үнэлгээ, орон нутгийн иргэд, засаг захиргааны бүтэц, цоохор ирвэсийн судалгаа ба хамгаалал, менежментийн төлөвлөгөөний зорилго ба зорилт гэсэн үндсэн 6 хэсэгтэй.

Менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа хамтрагч талуудын оролцоог хангаж, хамгаалалтын захиргааны ажилтнууд, оролцогч талуудад ойлгомжтой хэлбэрээр энгийн үг хэллэг ашиглан бичиж боловсруулсан болно. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад БНГ-ын онцлогт тохирч буй эсэхэд тогтмол үнэлгээ хийж, шаардлагатай гэж үзвэл тухай бүр нь шинэчлэн сайжруулах юм. Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн Хишиг” хөтөлбөр, Гурвантэс сумын хөгжлийн мастер төлөвлөгөөнд нийцүүлж уг менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

1.2 ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН, МЕНЕЖМЕНТ, ХЭРЭГЖИЛТИЙН МЕХАНИЗМ

ТХГН-ийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд, аймаг, сумын засаг дарга нь БНГ-ын хамгаалалтыг эрхлэх бүрэн эрхтэй гэж заажээ. Харин төрийн захиргааны төв байгууллага нь техникийн дэмжлэг туслалцааг үзүүлэх аж. 2019 оны 4-р сард, БОАЖЯ-ны Сайд Н.Цэрэнбат, Өмнөговь Аймгийн Засаг Дарга Н.Наранбаатар нар тус БНГ-ын менежментийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд тус гэрээнд талуудын үүрэг, хариуцлагыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- БОАЖЯ-ны Тусгай Хамгаалалттай Нутгийн Удирдлагын Газар нь стратегийн болон техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй бөгөөд ТХГН-ын хамгаалалтын захиргааны ажилтнуудын ажил үүргийн хуваарийг батална. Мөн БНГ-ын гүйцэтгэлийн үнэлгээг хийнэ.
- Өмнөговь аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газар нь холбогдох хууль тогтоомжийг биелүүлэх талаар заавар зөвлөгөө өгөх, аймгийн ИТХ-аар төсөв мөнгө батлуулах үүрэгтэй. Аймгийн захиргаа нь БНГ-ын үндсэн санхүүжилтийг

хариуцна.

- Гурвантэс сумын захиргаа нь хамгаалалтын захиргааны багийг бүрдүүлэх, менежментийн төлөвлөгөө боловсруулах, БНГ-ын дэглэмийг боловсруулах үүрэгтэй бөгөөд хамтын менежментийг хөхүүлэн дэмжиж, Хамтын Менежментийн Зөвлөл (ХМЗ), Аймгийн захиргаа, Яаманд тус нөөц газрын хамгаалалтын менежментийн явцын талаар тайлагнана. Мөн нутгийн иргэд болон хамтрагч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарч ажиллана.
- ИХС нь мэргэжлийн байгууллагын үүднээс БНГ-г хийгдэх мониторинг, судалгааны ажлыг хариуцна. Мөн нутгийн иргэдэд түшиглэсэн хамгаалалын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, талуудын чадавхийг бэхжүүлнэ. ИХС нь хамгаалалтын захиргааны багт ан амьтдын мониторинг хийх, мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх талаар зааж чиглүүлэхэд техникийн туслалцаа үзүүлж, ОУ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжин туслана.

**ТАНИЛЦУУЛГА,
НӨХЦӨЛ БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭ**

2



@ SLCF/SLT

2.1 АЛСЫН ХАРАА


“Нутгийн иргэдийн оролцоотойгоор Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын экосистемийг хамгаалж, унаган төрхөөр нь үр хойчдоо өвлүүлэн үлдээнэ”.

2.2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.2.1 Нутаг дэвсгэр

Тост, Тосонбумбын нурууны БНГ нь Монгол орны өмнө зүгт Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт оршдог (43.2'N, 100.5'E). Тус БНГ нь Дэлхийн Цоохор Ирвэсийн Экосистемийг Хамгаалах

Хөтөлбөрийн (ДЦИЭХХ) зорилтот 3 ландшафтын нэг болох Өмнийн говийн ландшафт хамарна. Энэ ландшафт нь хээр, цөл хээрийн уулархаг нутаг дэвсгэрийг хамарсан нийт 82,000км² талбай амьдрах орчин юм. (Газрын зураг 1).



Газрын зураг 1. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын байршил

Тост, Тосонбумбын нурууны БНГ нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун зүгт 320км зайд оршдог бөгөөд Говь Гурвансайханы БЦГ, Говийн Их ДЦГ-ыг холбосон ан амьтад дамжин өнгөрөх корридор нутгийн үүргийг гүйцэтгэдэг. Хойд талаараа, Говь Гурвансайхны БЦГ-ын ихэнхи нутагтай хил залгаа ба уулархаг хэсгээрээ Нэмэгт уулнаас 40км зайд цөлийн хээрээр тусгаарлагдан оршдог. Баруун талаараа Алтайн өвөр говиор дамжин Говийн Их Дархан Цаазат газрын “А” хэсэгтэй хиллэдэг. Тостын нуруунаас 400км орчим зайд Чинхай-Түвдийн өндөрлөгийн өмнөд зах Алашаа цөлөөр тусгаарлагдан оршдог.

Зүүн талаараа, хүн ам оршин суудаг суурин газартай хил залгаа бөгөөд зам, уул уурхайн компаниуд, Гурвантэс сумын төв, Ноён Уул бий.

Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын менежментийн төлөвлөгөө нь 896,540 га талбай бүхий өмнөд говийн цөл хээр, хад асга бүхий уулархаг нутгийг хамардаг. Уулсын төвөөс тал бүр тийш хөндий маягийн хавцал нэн түгээмэл бөгөөд уулын энгэр дагуух үргэлжилсэн тал хээр, чулуурхаг толгодуудтай. Энэ нь хойд болон баруун зүгт орших ан амьтдын амьдрах орчинг холбосон корридор нутгийг үүсгэдэг.

БНГ нь Тост багийн нутаг дэвсгэрт далайн дундаж түвшнээс 1600м-2400м өндөрт оршдог бөгөөд баруун өмнө хэсгээрээ Говийн их дархан цаазат газрын “А” хэсэгтэй, хойд хэсгээрээ Говь Гурвансайхан БЦГ-тай хиллэж ан амьтадын нүүдэллэн нутаглах гол корридор болдог. Тостын нурууны Хятад улсын хилтэй хамгийн ойр цэг нь 45км зайд байдаг. Тус БНГ нь цоохор ирвэсийг

хамгаалах өмнөд говийн хэсэгт багтдаг бөгөөд энэ нь Монгол орны хэмжээнд хамгаалахаар тогтоосон цоохор ирвэс нутагшдаг 3 газрын нэг нь юм. Цоохор


ирвэсний экосистемийг сэргээх өмнөд говийн хэсэг нь Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь аймгуудын нийт 82000 km² нутгийг хамардаг байна (Газрын зураг 2).



Газрын зураг 2. ДЦИЭХХ-ийн ландшафтууд

Тостын нуруунаас 400км орчим зайд Чинхай-Түвдийн өндөрлөгийн хамгийн урд зах Алашаа цөлөөр тусгаарлагдан оршдог. БНГ нь зүүн талаараа Гурван тэс сумын төвтэй хиллэдэг.

Тост, Тосонбумбын БНГ нь хязгаарлалтын бүс, хамгаалалтын бүс, орчны бүс гэсэн 3 бүсэд хуваагддаг (Газрын зураг 3). 2018 оны 12 сард Гурвантэс сумын ИТХ-ын 11 дүгээр тогтоолоор БНГ-ын дэглэмийг баталжээ.



Газрын зураг 3. Тост, Тосонбумбын нурууны БНГ, бүсчлэл

2.2.2 Хугацаа

Менежментийн төлөвлөгөө нь 2021 оноос 2025 оныг дуустал 5 жилийн хугацаатай хэрэгжинэ.

2.3 ЗОРИЛГО

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго нь “зорилтот төрөл зүйл, экосистемийг (цоохор ирвэс, түүний идэш тэжээл, устаж болзошгүй, ховор ургамлын төрөл зүйл, эртний түүх соёлын дурсгалт

газрууд) хамгаалах арга хэмжээг хамгааллын хөтөлбөрийн хүрээнд талуудын оролцоотой үе шаттай авч хэрэгжүүлэх ба санхүүгийн тогтвортой механизмыг бүрдүүлэхэд оршино.”

2.4 ХАМГААЛАХ ҮНЭТ ЗҮЙЛС

Хамгаалах үнэт зүйлс гэдэгт зайлшгүй хамгаалах шаардлагатай ан амьтдын амьдрах орчин, экологийн процесс, төрөл зүйл, түүх соёлын дурсгалт газрууд багтана. Эдгээр нь цогцоороо Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын биологийн олон янз байдлын төлөөлөл болох бөгөөд хамгаалалын арга хэмжээг эрэмбэ дараатай авч хэрэгжүүлэх, үр дүнг хэмжихэд гол үндэс суурь болно. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ийн биологийн олон янз байдал, экологийн онцлогийг илтгэсэн дараах 5 үнэт зүйлийг хамгаалахаар сонголоо. Үүнд:

- a) Цоохор ирвэс (*Uncia uncia*)
- b) Янгир ямаа (*Capria Sibirica*)
- c) Аргаль хонь (*Ovis Ammon*)
- d) Буйлс (*Amugdalus Mongolica*)
- e) Түүх соёлын дурсгалт газрууд (хадны сүг зураг, эртний хэрэгсүүр, г.м.)

2.4.1 Цоохор ирвэс (*Panthera uncia*)

Үндэслэл:

Өмнөд болон Төв Азийн өндөр уулархаг нутгуудад 4,000-7,500 цоохор ирвэс (*Panthera uncia*) нутагладаг гэсэн тооцоолол байна (МкКарти, Чапрон. 2003, Жаксон нар. 2010, Ирвэсний ажлын нарийн бичгийн дарга нарын газар. 2013). Монгол улсад 1,000 орчим цоохор ирвэс бүртгэгдсэн бөгөөд цоохор ирвэсний тоогоороо Монгол улс дэлхийд хоёрт ордог. (Мөнхцог ба нар., 2016). Цоохор ирвэс нь ОУ-н үнэлгээгээр “эмзэг” (МкКарти бус. 2017), МУ-ын 2000 оны Амьтны тухай хуулиар “нэн ховор” ангилалд багтдаг байна (Бадам, Ариунзул. 2005). Монгол улсад 1972 оноос хойш цоохор ирвэс агнахыг хориглосоор ирсэн бөгөөд 1995 оны ан агнуурын тухай хуулиар цоохор ирвэсийг

“нэн ховор” ангилалд багтаан хамгаалсаар иржээ (БОАЖЯ, 1996). 1987, 1997 оны Улаан номонд цоохор ирвэсийг “ховор” гэсэн ангилалд бүртгэжээ (Шагдарсүрэн нар., 1987, Шийрэвдамба, бус., 1997). Цоохор ирвэсний амьдрах орчны 18 хувь нь Монгол орны тусгай хамгаалалтын бүсэд багтдаг бөгөөд хад асга бүхий ууланд амьдарч, тал хээрээр дамжин уулс хооронд сэлгэдэг байна (Зураг 1). Гол идэш тэжээл нь янгир, аргаль байх ба цоохор ирвэсэнд учирч буй аюул дарамтанд өширхөн хороох, хууль бусаар агнаж худалдаалах, идэш тэжээлийн хомсдол, уул уурхай, уур амьсгалын өөрчлөлт зэрэг багтана (МкКарти нар., 2017).



Зураг 1. Цоохор ирвэс

Одоогийн төлөв байдал


Монгол улсад цоохор ирвэсийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтанд авсан хамгийн анхны газар нь Тост, Тосонбумбын нуруу юм. Тус нутаг нь Монголд төдийгүй дэлхийн хэмжээнд цоохор ирвэсний нягтшилаараа хамгийн өндөрт тооцогддог газруудын нэг. Тус БНГ-ын 1500 орчим ам дөрвөлжин нутаг дэвсгэрт цоохор ирвэс нутагладаг бөгөөд үлдсэн газар нутгаар дамжин өнгөрдөг байна.

ИХС ТББ, ОУИХС нь 2008 оноос хойш БОАЖЯ, орон нутгийн иргэдтэй хамтран цоохор ирвэсний урт хугацааны экологийн

судалгааг хийсээр ирсэн. Тостын нуруунд хийгдэж буй судалгааны гол чиглэл нь цоохор ирвэсийн орон зайн экологи (эзэмшил нутгийн хэмжээ, цоохор ирвэс хоорондын харилцаа), идэш тэжээл (ямар төрлийн амьтныг хэр давтамжтай барьж иддэг болох), цоохор ирвэсний болон идэш тэжээлийнх нь популяци (тоо толгой), нийгэм-экологи (нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд нь уламжлалт мал маллагаа, аж амьдралд хэрхэн нөлөөлж байгаа) зэрэг юм.

Тостын нуруу болон зэргэлдээх уулсад орших цоохор ирвэсүүд нь хад асга бүхий ууланд бүгдэг бөгөөд зарим тохиолдолд уул

сэлгэхээр тал газраар яваа харагддаг (Иоханссон нар., 2016). Тостын нуруу, Нэмэгт уулыг холбосон цөл хээрээр гурван залуу цоохор ирвэс явж байсан тохиолдол бий. (ОУИХС, албан бус мэдээ) (Газрын зураг 4). Ийнхүү уул сэлгэх нь цоохор ирвэсүүд хоорондоо холбоотой болохыг илтгэх тул тэдгээрийг нэг популяцид хамруулан цогцоор нь судлах нь зүйтэй. Цоохор ирвэсүүд уул сэлгэхдээ тал газраар дамжин өнгөрдөг нь Өмнөд говийн цөл хээрийн нутаг цоохор ирвэсийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна.




Газрын зураг 4. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын ан амьтдын тархац

Нэг цоохор ирвэс багагүй том талбайг эзэмшин оршдог. Тухайлбал, гэнд буюу эр ирвэс 220 км², гинс буюу эм ирвэс 125 км² нутгийг эзэмшдэг. (Иоханссон нар., 2016). (Газрын зураг 5) Зарим тохиолдолд цоохор ирвэс эзэмшил нутгийнхаа хил хязгаарыг давж 50 км зайд хэрэн хэсүүчилдэг нь орчны бүстэйг илтгэнэ (Иоханссон нар., 2016). Цоохор ирвэсүүд эзэмшил нутагтаа эзэрхэг бөгөөд харам (өөрөөр хэлбэл, хүйс ижил

ирвэсийг эзэмшил нутагтаа оруулдаггүй). Бие гүйцсэн адил хүйсийн цоохор ирвэсүүдийн эзэмшил нутаг давхцдаггүй (Иоханссон нар., 2016, Иоханссон нар., 2018). Нэг эзэмшил нутагт хоёр гэнд эсвэл хоёр гинс байх тохиолдол маш ховор. Цоохор ирвэсний эзэмшил нутагт хүн амьдарч болдог ба хүний уламжлалт ахуй амьдрал цоохор ирвэсэнд ямар нэг сөрөг нөлөө үзүүлдэггүй байна (ОУИХС, албан бус мэдээ).

Тостын нурууны цоохор ирвэсүүдийн гол идэш тэжээл нь янгир. Хавар, зун, намрын идэш тэжээлийнх нь 75%-ийг янгир, 20% орчим хувийг хонь, ямаа эзэлж байна (Шезад

нар, 2012, Иоханссон нар., 2015). Багаахан хувийг аргаль, адуу, залуу тэмээ, хахилаг эзэлж байна (Шезад нар., 2012, Иоханссон нар., 2015).



Газрын зураг 5. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын цоохор ирвэсний амьдрах орчин

Цоохор ирвэс нь дунджаар 8 өдөрт нэг удаа том ан хийдэг бөгөөд олзныхоо ойр 3-4 хоног эргэлдэж хооллодог. (Грүнберг 2011, Иоханссон нар., 2015). Нэг цоохор ирвэс жилдээ 45 том ан хийдэг, үүнээс 9 нь хонь, ямаа байдаг гэсэн тоо баримт нь судалгааны дүнтэй таарч байна. Тостын нурууны цоохор ирвэст бариулсан хонь, ямааны 62% нь сүргээсээ тасарч үлдэж, шөнийн цагаар бариулжээ. Малчидтай хийсэн ярилцлагын дүнгээс харахад, цоохор ирвэст бариулсан малынх нь тал хувь нь сүргээсээ тасарч эзгүй хээр үлдсэн байсан гэж хариулсан нь дээрх судалгааны тоо баримттай ойролцоо байна (Мижиддорж нар., 2018).

Тостын нуруунд нутагладаг бие гүйцсэн цоохор ирвэсний тоо толгой 2009-2012 онд 12-оос 14-ийн хооронд, 2013-2019 онд 10-аас 19-ийн хооронд хэлбэлзжээ (Шарма нар., 2014, ОУИХС, албан бус мэдээ). Зэрлэг амьтдын тоо толгой жилээс жилд хэлбэлзэх нь хэвийн үзэгдэл бөгөөд 2009-2019 онд хийсэн мониторинг судалгаагаар,

цоохор ирвэсний тоо толгой 10-аас 19-ийн хооронд хэлбэлзжээ (Шарма нар, 2014, ОУИХС, албан бус мэдээ). Тостын нуруунд бие гүйцсэн цоохор ирвэсээс гадна эзэмшил нутгаа эрэн хайж буй 1-4 залуу цоохор ирвэс байна (ОУИХС, албан бус мэдээ). Тостын нуруунд амьдардаг гинсийн үр төл болох 2 настай гүем эхийнхээ эзэмшил нутгийн ойр 1-2 жил амьдарч байгаад тус нурууг орхин явжээ. Тоо толгойн хэлбэлзэл нь үүнтэй холбоотой байж болох юм. Зарим залуу цоохор ирвэсүүд эзэмшил нутгаа эрж олохоор ойролцоох уулс руу явж байгаагаас харахад Тостын нуруу нь Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэг, Говь Гурвансайхны БЦГ хооронд дамжин өнгөрөх гол гүүр болж байна. Цаашид цоохор ирвэсний тоо толгой, хэлбэлзлийг үргэлжлүүлэн судалж, нөлөөлөх хүчин зүйлсийг олж тогтоох нь чухал юм.

Судалгаагаар бид чухал, шинэ мэдээлэл олж авч байгаа бөгөөд энэ нь цоохор ирвэс, түүний идэш тэжээлийн экологийн судалгааны суурь юм. Цаашид,

цоохор ирвэсний нөхөн үржихүй, (хэдэн гүем төрүүлдэг, хэр ойрхон хээлтдэг, хэдэн насандаа нийллэгт ордог), амьдрах чадвар, тархац (ө.х. нэг нутгаас нөгөө нутаг руу хэр хол замыг туулж хэр давтамжтай сэлгэдэг), тоо толгойн хэлбэлзэл зэргийг судлах шаардлагатай байна. Эдгээр мэдээлэл нь цоохор ирвэсийг хамгаалахад чухал үүрэгтэй бөгөөд гагцхүү цоохор ирвэс нэг бүрийг урт хугацааны туршид ажиглаж судалснаар дээрх мэдээллийг олж авах боломжтой.

Аюул дарамт

Мал барьсны төлөө хороох (нийт оноо=14). Энэ нь цоохор ирвэсэнд учирч буй дарамтуудаас хамгийн өндөр оноотойгоор эрэмбэлэгдсэн. 2008-2019 онд Тостын нурууны хүзүүвчтэй 32 цоохор ирвэсийн 4-ийг мал барьсны төлөө хороожээ. Хүзүүвчний мэдээллээс харахад, тэдгээр ирвэс айлын хоттой мал руу дайрсан байх бөгөөд түүнээс хойшхи мэдээлэл байхгүй байна. Хамгийн сүүлийн байршлаар, нэг хүзүүвчтэй ирвэс нь малын хотон дотор, нөгөө нь малын хотноос хэдэн км-ийн зайд байжээ. 2010-2018 онд хүзүүвчтэй цоохор ирвэсийг мал барьсны төлөө хороосон тохиолдол дахиж гараагүй байна (Иоханссон нар, 2015).

Ийнхүү мал барьсны төлөө өширхөн хороох явдал нь тус БНГ-ын цоохор ирвэст учирч буй нэг гол аюул дарамт болж байна. Малчид дунджаар малынхаа 5 орчим хувийг цоохор ирвэс ба чононд алдаж байгаа нь тэдний аж амьдралд багагүй төвөг учирч байгаа бөгөөд зарим жилд малынхаа 20 орчим хувийг ч эдгээр амьтдад бариулсан тохиолдол байна (Мижиддорж нар, 2018., Самелиус нар 2020).

Хууль бус агнуур (нийт оноо = 9). Цоохор ирвэсийг ямар зорилгоор хууль бусаар агнадаг талаарх мэдээлэл байхгүй байна. Цоохор ирвэсийн арьс шир, эд эрхтэнг зарах нь цоохор ирвэсийг хороосноос ялгаагүй шийтгэлтэй аж. ОУ-ын хэмжээнд цоохор ирвэсийн арьс шир, эд эрхтэний эрэлт хэрэгцээ төдийлөн их биш байгаа ч нэмэлт орлого олох зорилгоор хууль бусаар агнах нь өширхөн хороох асуудал дээр давхар дарамт учруулж байна (EIA 2012).

Хавх тавих, хордуулж хороох (нийт оноо=9). 2009 онд чоно барих гэж тавьсан хавханд цоохор ирвэс орсон тухай хоёр малчин өөрсдөө мэдээлсэн. Зарим тохиолдолд гурван хөлтэй нохой тус нутгаар

үзэгддэг нь санаандгүй чонын хавханд орсон байх магадлалтай. Ямартай ч хавх тавих асуудал цоохор ирвэст учирч буй бас нэг аюул дарамт юм.

ЗОРИЛГО 1: Тост, Тосонбумбын нурууны БНГ дахь цоохор ирвэсийн популяци, түүний амьдрах орчин 2025 он хүртэл тогтвортой хэвээр байна. (Шалгуур үзүүлэлтүүд; Бие гүйцсэн ирвэсийн тоо, бие гүйцсэн эм бодгалийн эзлэх хувь ба тархац нутгийн хэмжээ, ирвэсийн идэш тэжээлийн хүрэлцээтэй байдал)

2.4.2 Янгир ямаа (*Capria sibirica*)

Үндэслэл

Олон орны үнэлгээгээр—анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн үнэлгээгээр - устаж болзошгүй

Үндэсний үнэлгээгээр - 2001 оны Амьтны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ховор ангилалд оруулсан (Бадам ба Ариунзул, 2005). 1995 оны Ан агнуурын тухай хуулиар ховор ангилалд оруулсан (БОЯ, 1996). 1987, 1997 оны Монголын Улаан номонд ховор ангилалд бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар., 1987; Шийрэвдамба нар., 1997). Янгир ямааны 14 орчим хувь нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутагт нутагшиж байна.



Зураг 2. Янгир ямаа

Янгир ямаа (*Capria sibirica* цаашид янгир гэх) нь төв Азийн уулсаар нутагладаг бөгөөд тэдгээрийн тархац цоохор ирвэсний тархацтай хойд болон баруун хэсгээрээ давхцаж байна (Рийдинг ба Шанк 2008, МкКарти нар., 2017). Монгол орны Алтай, Хангай, Говь-Алтайн уулсаар янгирын популяцийн ихэнхи нь нутагшидаг бөгөөд Саяаны уул (Хөвсгөл нуурын баруун хэсэг), УБ-ын Богд ууланд цөөн тоо толгой бүртгэгдсэн байна (Рийдинг ба Шанк 2008). Янгирт учирч буй аюул дарамтад тэдгээрийг олноор нь агнах, махыг нь хэрэглэх гэж хууль бусаар агнах, амьдрах орчин нь хумигдаж буй зэрэг багтана (Рийдинг ба Шанк 2008).

Одоогийн төлөв байдал

2012 оноос хойш Тостын нурууны янгир ямааны тоо толгойг тогтоох чиглэлээр цоохор ирвэсний урт хугацааны судалгааны хүрээнд хос ажиглалтын мониторинг хийж ирлээ (Төмөрсүх нар., 2015). Мониторинг судалгаа нь уулын туруутныг голлон ажиглаж байгаа тул тал хээрийн туруутны талаарх мэдээлэл бага байна. Судалгаагаанаас үзэхэд янгир ямаа нь хад асга ихтэй өндөр уулсаар, аргаль нь хад асга багатай уул толгодоор ихэнхидээ бэлчдэг байна (Төмөрсүх нар, 2015, О.Чагсалдулам 2020) (Зураг 2).

2012-2019 онуудад Тостын нурууны янгир ямааны тоо толгойд өөрчлөлт ороогүй, харьцангуй тогтвортой байна. Одоогоор 1000-2000 толгой янгир ямаа бий гэсэн судалгаа байна (Төмөрсүх нар., 2015, О.Чагсалдулам 2020).

Аюул дарамт

Тус БНГ дахь зэрлэг туруутанд түгээмэл учирч буй аюул дарамт нь *гэрийн мал туруутан амьтны бэлчээрийн төлөөх өрсөлдөөн, хууль бус агнуур, өвчин тахал, золбин ноход* орж байна. Эдгээрээс эхний хоёр нь хамгийн өндөр оноотойгоор эрэмбэлэгджээ.

Бэлчээрийн төлөөх өрсөлдөөн (нийт оноо = 11) Малын тоо толгой өссөн нь бэлчээрийн чанарт сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд Монгол орны тал хээрийн 70% нь бэлчээрийн талхагдалд оржээ (UNEP 2002, Ykhanbai нар., 2004, Хилкер нар., 2014). Бэлчээрийн даац, мал ба зэрлэг туруутны бэлчээр ашиглалтын талаар судлах нь бэлчээрийн зүй зохистой менежментэд чухал ач холбогдолтой (Бергер нар., 2013).

ҮСХ-ны мэдээллээр, Тост багийн нутаг дэвсгэрт хонь, ямааны тоо толгой 2012 оноос 2018 оны хооронд 29,800- 52,000 болж 53% өсчээ. 2012 оноос өмнөх мэдээлэл байхгүй байна. Тус БНГ-ын байгаль хамгаалагчдын мэдээллээс хархад, 2016 онд туруутан ба малын бэлчээр булаалцалдах асуудал маш хурцадмал байсан бөгөөд туруутныг байгаль орчин сүйтгэдэг гэж малчид үздэг байжээ. БНГ-т амьдарч буй малчин өрхийн тоо, бэлчээрийн төлөв байдал жилээс жилд янз бүр байгаа бөгөөд энэ нь тухайн жилийн бэлчээрийн чанар, хур тунадас зэргээс шалтгаалж малчид нүүдэллэж байгаатай холбоотой. Жишээлбэл, 2017/2018 онд

олон тооны малчин өрх Тостын нуруунд өвөлжихөөр буусан нь тус газрын бэлчээрийн даацад сөргөөр нөлөөлж байжээ.

2012 оноос хойш зэрлэг туруутны тархац, тоо толгойд хийсэн мониторинг судалгаагаар, зэрлэг туруутны тоо толгой өөрчлөгдөөгүй харьцангуй тогтвортой байна (ИХС судалгааны тайлан 2019). Зэрлэг амьтдад зориулж шинээр уст цэг гаргасан нь бэлчээрийн даацыг хэтрүүлэх, зөрчилдөөн үүсгэх сөрөг нөлөөтэй байж магадгүй байна. Учир нь малчид өмнө нь мал бэлчдэггүй байсан газар ус даган малаа бэлчээх хандлагатай болжээ. 2018-2019 онд зэрлэг амьтдад зориулж гаргасан уст цэгийг дагаж их хэмжээгээр мал бэлчсэн гурван тохиолдол бий. Өмнө нь малын бэлчээр биш байсан газрыг ийнхүү бэлчээр болгон ашиглах явдал ихсэж байна. Тиймээс хамгаалалтын албаны удирдлагууд зэрлэг амьтдад зориулж уст цэг гаргахдаа сайтар төлөвлөж, зөвлөлдөж, малын бэлчээр болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах нь зүйтэй.

Хууль бус агнуур (нийт оноо = 6) Цоохор ирвэсний идэш тэжээл бологч энэхүү амьтны хууль бусаар агнах явдал тодорхой хэмжээгээр гарч байна. Мөн Тостын нурууны туруутнууд тэр дундаа янгирыг агнах явдал элбэг байна.

Зорилго 2: 2025 он гэхэд БНГ-н янгирын популяцийн амьдрах орчин 90% ба түүнээс дээш хувь болж сайжирсан байна (сайжирах гэдэг нь = мэнд үлдэх чадварын үнэлгээний дагуу нөхцөл байдал сайн эсвэл түүнээс дээш гэсэн үзүүлэлттэй). Шалгуур үзүүлэлтүүд: Янгирын элбэгшил ба нягтшилын үзүүлэлт, бие гүйцсэн эм янгирын сүрэгт эзлэх хувь, нэг эм янгирт ногдох ишигний тоо, тархац нутгийн хэмжээ.

2.4.3 Аргаль хонь (*Ovis ammon*)

Үндэслэл:

Олон улсын үнэлгээгээр - эмзэг, A2cde. Говийн аргаль (*O.a. darwini*) устаж болзошгүй, C1, Алтайн аргаль (*O.ammon*) эмзэг, A2cde and C1.

Бүс нутгийн үнэлгээгээр - устаж болзошгүй.

Үндэсний үнэлгээгээр - 2001 оны Амьтны

тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ховор ангилалд багтаан хамгаалсан (Бадам ба Ариунзүл, 2005).

Аргаль агнахыг 1953 оноос эхлэн хориглосон бөгөөд 1995 оны ан агнуурын тухай хуулиар ховор ангилалд багтаасан (БОЯ, 1996). 1987, 1997 оны Монгол Улсын Улаан номонд ховор ангилалд бүртгэсэн (Шагдарсүрэн нар, 1987.; Шийрэвдамба нар., 1997). Тус төрөл зүйлийн 14% орчим нь тусгай хамгаалалтай газар нутагт оршдог. Аргаль хонь нь *Өмнөд болон Төв Азийн уулархаг нутгаар амьдардаг бөгөөд тэдгээрийн тархац нь цоохор ирвэсний тархацтай давхцдаг (Харрис ба Рийдинг 2008, МкКарти нар 2017). Монгол оронд аргалийн популяцийн ихэнхи нь Алтай, Хангай, Говь-Алтайн уулсаар нутагшдаг. Гэхдээ Хөвсгөл нуур орчмын зарим уулархаг нутагт цөөн тоогоор бий (Рийдинг нар, 2001). Аргаль нь хад асгагүй уул толгод, өндөрлөг газраар бэлчдэг (Шаллер 1977). Аргальд учирч буй гол аюул дарамтад, тэдгээрийг олноор нь агнах хууль бус агнуур, бэлчээрийн өрсөлдөөн, амьдрах орчин хумигдал зэрэг багтана (Харрис ба Рийдинг. 2008).*



Зураг 3. Аргаль хонь

Одоогийн төлөв байдал

2012 оноос хойш Тостын нурууны аргалийн популяцид цоохор ирвэсний урт хугацааны судалгааны хүрээнд хос ажиглалтын арга ашиглан мониторинг судалгаа хийсээр байна (Төмөрсүх нар., 2015). Судалгаагаар, 200-400 орчим аргаль байгаа нь тогтоогджээ (Зураг 3).

Янгиртай харьцуулахад, аргаль хонь нь уулын хад асгагүй хэсгээр бэлчдэг тул малтай бэлчээр булаалцалдах асуудал илүү

гардаг байна. Уулын нам дор хэсэг буюу мал бэлчдэг хэсгээр бэлчээрийн доройтол харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна (Зара Моррис-Трэйнор 2019).

Аюул дарамт

“Янгир ямаанд учирч буй аюул дарамт” хэсгийг үзнэ үү.

Хамгаалах үнэт зүйл: Аргаль хонь (Ovis Ammon)

Зорилго 3: 2025 он гэхэд БНГ-н аргаль хонины популяцийн амьдрах орчин 80% ба түүнээс дээш хувь болж сайжирсан байна (сайжирах гэдэг нь = мэнд үлдэх чадварын үнэлгээний дагуу нөхцөл байдал сайн эсвэл түүнээс дээш гэсэн үзүүлэлттэй). Шалгуур үзүүлэлтүүд: Аргаль хонины элбэгшил ба нягтшилын үзүүлэлт, бие гүйцсэн эм янгирын сүрэгт эзлэх хувь, нэг эм янгирт ногдох ишигний тоо, тархац нутгийн хэмжээ

2.4.4. Монгол буйлс (*Amygdalus Mongolica*)

Үндэслэл

Бүс нутгийн үнэлгээгээр: Устаж болзошгүй. 1987, 1997 оны Улаан ном болон 1995 оны ургамал хамгаалах хуулинд нэн ховор ангилалд бүртгэгдсэн (Монгол орны ургамлын улаан данс ба байгаль хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө, 2011). Зүүн говь (Галбын говь) Говь-Алтай (Хүрх уул), Алашаа цөл (Борзонгийн говь, Онч хиар)-ийн нутгаар ургадаг (Грубов 1982, Губанов 1996, Монгол орны улаан ном 1987&1997).



Зураг 4. Монгол буйлс

Ургамлын энэ төрөл зүйл нь цөлийн бүсэд хад чулуутай газар, элсэн манхан, элсэрхэг чулуун толгод, сайр, ширгэж хатсан

голын ай саваар ургадаг. (Зураг 4). Энэ төрөл зүйлд учирч буй гол аюул дарамтанд, амьдрах орчны талхлагдал, ХАА, мал, уур амьсгалын өөрчлөлт, нөхөн үржихүй, нягтшил бага, тоо толгойн хэлбэлзэл зэрэг орно.

Одоогийн төлөв байдал

Ц.Энх-Өлзийгийн 2011 онд хийсэн магистрийн ажлын судалгаагаар, тус БНГ-т Монгол буйлс (*Amygdalus Mongolica*), Улаан тулам (*Incarvillea Potatnirii*), Эгэл шишингэ (*Phragmites communis*), Намхан гишүүнэ (*Rheum nanum Sievers*), Монгол азар (*Calligonum mongolicum Turcz*), Сибирь ерөндөг (*Vincetoxicum sibiricum*), Монгол дагуур (*Caryopteris Mongolica Bge*) гэсэн нийт 7 нэн ховор ургамлын төрөл зүйл байгаа нь тогтоогджээ (Хавсралт – Ургамлын олон янз байдал). Хэдийгээр хамгаалах үнэт зүйлсэд энэ ургамлын төрөл зүйлийг оруулсан ч чухам ямар аюул дарамт учирч байгаа талаарх мэдээлэл хомс байна. Нутгийнхны яриагаар, эдгээр төрөл зүйлийг эмчилгээнд болон зарж борлуулах зорилгоор их хэмжээгээр хууль бусаар түүдэг байна (Ранжини нар., 2018). Тиймээс БНГ-ын менежментийн дараагийн үе шатанд энэ талаар нарийвчлан судлах нь зүйтэй. Монгол орны Ургамал хамгааллын хуулиар нэн ховор ангилалд багтдаг аливаа ургамлын төрөл зүйлийг түүх нь хууль бус үйлдэл аж.

Зорилго 4: 2025 он гэхэд БНГ дахь Монгол буйлсаар төлөөлүүлсэн ховор ургамлын төрөл зүйлийн судалгаа хийгдэж тогтвортой ашиглалт хамгааллын менежмент сайжирсан байна. Шалгуур үзүүлэлтүүд: тохиолдоц, төрөл зүйлийн тоо гэх мэт.

2.4.5. Археологийн түүх соёлын дурсгалууд

Үндэслэл

Ардын хувьсгал ялсан 1921 оноос 1950 он хүртэлх хугацаанд Монгол улс гадаадын эрдэмтэдтэй хамтран байгаль орчин, газар зүй, түүх, соёлын чиглэлээр эрдэм шинжилгээний чамгүй судалгаа, эрэл хайгуулыг хийжээ. 1940 оноос Монголын эрдэмтэдийн баг бие даан Өмнөд говийн бүс нутгуудаар эрэл хайгуул хийдэг болж, Чулуун

зэвсгийн үеийн түүх соёлын олдворууд олжээ.



Зураг 5. Хадны сүг зураг

1988 онд Гурвантэс сум болон өөр хэд хэдэн суманд археологийн хайгуул хийж хадны сүг зураг, чулуун дурсгалууд олж бүртгэжээ. Археологийн олдворуудад дүн шинжилгээ хийхэд Өмнөд говийн соёлын өв нь Чулуун зэвсгийн үед (МЭӨ 3000-1000) хамаарч байгаа нь тогтоогджээ (Б.Гүнчинсүрэн нар, 2010) (Зураг 5).

Одоогийн төлөв байдал

2016 онд Улаанбаатар их сургуулийн оюутны баг тус БНГ-ын 5 хувийг хамарсан түүх соёлын дурсгалт газруудад судалгаа хийжээ. Судалгаагаар, 28 цэгээс 202 археологийн олдворуудыг тоолж бүртгэсэн байна. Үүнд, Чулуун зэвсгийн үеийн 174 хадны сүг зураг (МЭӨ 3000-1000), 15 дугуй булш, 1 дөрвөлжин булш, 1 шоргоолжин булш, Их Монгол орны үеийн (1300-1600 он) 9 булш, хугацаа нь тодорхойгүй 2 тахилын ширээ бүртгэгджээ. Цаашид ийм ижил төстэй судалгаанд БНГ-ыг бүхэлд нь хамруулж, археологийн дурсгалт газруудын байршлыг олж тэмдэглэн, газар зүйн байршлын зураглал гаргах нь зүйтэй. Хамгааллын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эдгээр судалгааны үр дүнд үндэслэж дурсгалт газруудыг хэрхэн удирдан зохицуулах талаар бодож боловсруулах юм. Тиймээс цаашдын судалгаа зайлшгүй чухал. Энэхүү үнэт зүйлсийн талаарх мэдээлэл хомс бөгөөд олдворуудыг хулгайлах, ухаж төнхчих тохиолдол хэд хэдэн удаа гарчээ. Тиймээс бүртгэж баримтжуулах ажлыг даруй эхлүүлэхгүй бол дээрх үйлдэл газар авч түүх соёлын дурсгалт газруудыг сүйтгэж болзошгүй. Үүнээс гадна, археологийн дурсгалт газруудыг хамгаалах нь ирээдүйд боловсрол соёлын хүрээнд эко аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Зорилго 5: 2025 он гэхэд БНГ дахь археологи түүх соёлын дурсгалын судалгаа хийгдэж хамгааллын менежмент сайжирсан байна. (шалгуур үзүүлэлтүүд: дурсгалт газрын тоо, нөхцөл байдлын үнэлгээ)

2.5 ХАМГААЛАХ ҮНЭТ ЗҮЙЛҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээг 3 төрөлд хамаарах экологийн чухал хүчин зүйлийн шалгуураар үнэллээ. Зарим үнэт зүйлсийн (Монгол буйлс, Археологийн дурсгал) мэдээлэл хангалтгүй байсан тул бүрэн гүйцэт үнэлэх боломжгүй байв.

Хүснэгт 1-т тодорхой тооны шалгуур

үзүүлэлтийн дагуу мэдээллийг оруулав. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх замаар үр дүнд чиглэсэн менежментийг хэрэгжүүлэхэд анхааран төлөвлөлтийг хийсэн болно.

Хүснэгт 1. Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлыг үнэлэх шалгуурууд

Үнэт зүйлс	Экологийн гол хэмжээс	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн түвшин			
			Муу	Дунд	Сайн	Маш сайн
Цоохор ирвэс	Популяцийн хэмжээ	Бие гүйцсэн ирвэсийн тоо	<8	8-10	10-15	>15
	Популяцийн бүтэц	Бие гүйцсэн эм бодгалийн эзлэх хувь	<30%	30-50%	50%	50-60%
	Тархалт	Ирвэсийн популяцийн тархалт	<50% тохиромжтой амьдрах орчин	50-80% тохиромжтой амьдрах орчин	80- 90% тохиромжтой амьдрах орчин	90- 100% тохиромжтой амьдрах орчин
	Идэш тэжээлийн хүрэлцээ	Ирвэсийн идэш тэжээлийн хүрэлцээ (доороос янгирыг харна уу)				
Аргаль	Популяцийн хэмжээ	Хос ажиглагчийн үр дүнд гарсан элбэгшил, нягтшилын үзүүлэлт	<100	100-120	150-200	>250
	Популяцийн бүтэц	Үржлийн насны эм бодгалийн эзлэх хувь	<20%	30-40%	40-50%	50%
	Тархалт	Аргалийн популяцийн тархалт	<50% тохиромжтой амьдрах орчин	50-80% тохиромжтой амьдрах орчин	80- 90% тохиромжтой амьдрах орчин	90- 100% тохиромжтой амьдрах орчин
	Бэлчээрийн нөхцөл байдал?	Уулархаг бүсийн доройтлын үзүүлэлт, НЯУИ(NDVI) хүрээ				

Янгир	Популяцийн хэмжээ	Хос ажиглагчийн үр дүнд гарсан элбэгшил, нягтшилын үзүүлэлт	<500	500-1000	1000-1800	>1800
	Популяцийн бүтэц	Үржлийн насны эм бодгалийн эзлэх хувь	<20%	30-40%	40-50%	50%
	Тархалт	Янгирын популяцийн тархалт	<50% тохиромжтой амьдрах орчин	50-80% тохиромжтой амьдрах орчин	80- 90% тохиромжтой амьдрах орчин	90- 100% тохиромжтой амьдрах орчин
	Бэлчээрийн нөхцөл байдал?	Уулархаг бүсийн доройтлын үзүүлэлт, НЯУИ(NDVI) хүрээ	>10% жилийн бууралт	>5% жилийн бууралт	Буураагүй	Ургамалын индекс өсөж байгаа(?)
Монгол буйлс (ховор ургамал)	Зүйлийн тоо	Ховор зүйлийн # (Устаж болзошгүй 6 зүйл, Улаан дансанд бүртгэлтэй 10 зүйл	>12	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Ховор ургамлын хамгаалалт
	Тархалт	Ховор ургамлуудын зүйлийн тархалт	>10% жилийн бууралт	>5% жилийн бууралт	Буураагүй	Тархалтыг нэмэгдүүлэх
Археологийн дурсгал	Урт хугацаанд оршин тогтнох	Орон нутгийн иргэдийн угсаатны экологийн талаар мэдлэг	Шалгуур үзүүлэлтүүдийг тодруулах судалгааны явцад			
		Тухайн газарт тодорхойлсон олдворын тоо(газар нутгийн 10%-д 256)	10%	10-30%	30-70%	70-100% бүртгэлтэй байх
		Олдворуудын нөхцөл байдал	30%-с бага	30-59%	60-89%	Хамгаалах

Хүснэгт 2. Аюул дарамтын нийлбэр үнэлгээ

Маш сайн - Экологийн хувьд унаган төрхөө хадгалсан байдал; хамгаалах үйл ажиллагаа тэр болгон хэрэгтэй биш

Сайн- Хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэлзлийн заагт байгаа үзүүлэлт; зарим тохиолдолд хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай.

Дунд- Хэлбэлзлийн зөвшөөрөгдөх хязгаараас гарсан; хүний сөрөг нөлөө орсон

Муу- Дахин сэргээхэд хүндрэлтэй; тухайн зүйл устгах аюулд хүрсэн

2.6 АЮУЛ ДАРАМТ

ИХС, ОУИХС-ийн баг Тост, Тосонбумбын нурууны БНГ-т тулгарч буй аюул дарамтыг судалгаа шинжилгээний баримтад үндэслэж хамтрагч талуудын оролцоотойгоор тодорхойлж, үнэлгээ хийсэн болно (Хүснэгт 2).

2.6.1 Бэлчээр, мал

ХАА нь Монгол орны эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортод чухал үүрэг гүйцэтгэдэг. 2013 онд, ХАА-н нийт бүтээгдэхүүний 80% нь малын гаралтай бүтээгдэхүүн байсан бөгөөд энэ нь ДНБ-ий 10.6 хувийг бүрдүүлжээ (ҮСХ, 2019). МАА-с ДНБ-д оруулах хувь багассан хэдий ч нийт ажил эрхлэлтийн 35%-ийг МАА эзэлж байна. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд малчин өрхийн 30% нь малынхаа ашиг шимийг хүртэн амьдарч байна (ҮСХ 2019).

Гурвантэс сум нь 225,294 тоо толгой малтай бөгөөд үүнээс 61,930 тоо толгой нь Тост, Тосонбумбын нурууны БНГ-т амьдардаг 201 малчин өрхийнх аж (Хүснэгт 3) ҮСХ 2019). Нийт тоо толгойн ихэнхи хувийг ямаа, хонь, багаахан хэсгийг адуу, тэмээ, цөөн тооны үхэр эзэлж байна.(Хүснэгт 3).

Гурвантэс сумын нийт 2,8 сая га газар нутгийн 1.4 сая га буюу 50.7% нь бэлчээр

байх бөгөөд 1га бэлчээрт дунджаар 20кг өвс тэжээл ургадаг байна. (ҮСХ 2019).

Тост багийн нэг өрхөд 209.7 толгой мал (хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ нийлээд) ногдож байна (Цэрэннадмид нар., 2018). 2015 -2019 онд Тост багийн малын тоо толгой 53%-иар өсчээ. Зах зээлийн системд шилжсэнээс хойш БНГ дахь нийт малын тоо өссөн хэдий ч малчид ямаа голдуу маллах болж бусад төрлийн малын тоо буурчээ. 1997 онд нийт малын 79%-ийг ямаа эзэлдэг байсан бол 2016 онд энэ дүн 89% болж өсчээ (Зара Моррис-Трэйноор, 2019).

Тус БЦГ-т малчид цоохор ирвэстэй зохицон амьдрахад асуудалтай болж эхэлсэн. Нууцаар хууль бус ан хийж ул мөрөө балладаг тул бодитой судалгаа, тоо баримт байдаггүй. Цоохор ирвэсийг агнах дэлхий нийтэд түгээмэл нэг шалтгаан нь мал барьсных нь төлөө өширхөж, эсвэл урьдчилан сэргийлж хороох байсаар байна. (Цоохор Ирвэс Хамгаалах Холбоо 2014). Дэлхий даяар ан амьтдыг хууль бусаар агнаж, худалдаалах явдал газар авч байгаа бөгөөд хууль бус агнуурын цар хүрээ, хор уршигийн талаарх судалгаа бага байна (Ноуэл нар., 2016).

Хүснэгт 2. Хамгаалах үнэт зүйлсийн тулгарч буй аюул заналийн үнэлгээ

Хамгаалах үнэт зүйлс Тулгарч буй аюул заналийн үнэлгээ	Аргаль	Монгол буйлс	Цоохор ирвэс	Хадны сүг зураг хиргэсүүр	Янгир	Нийлбэр
Цоохор ирвэс хүний хоорондын зөрчил			Маш их			Их
Уул уурхай хөгжлийн хөтөлбөрүүд	Бага		Бага	Бага	Бага	Бага
Малын хэт их өсөлт бэлчээр түрэлт	Дунд		Дунд		Дунд	Дунд
Байгалийн гамшигт үзэгдэл (зуд ган)-ийн давтамж өндөрсөх усны хомсдол	Маш их	Маш их	Маш их	Маш их	Маш их	Маш их
Хуулийн журмын хэрэгжилт муу	Дунд		Дунд		Дунд	Дунд
Үнэт зүйлдс учирч буй аюул заналын нийлбэр	Их	Их	Маш их	Их	Их	Маш их

Хүснэгт 3. Тост багийн малын тоо толгой (ҮСХ 2019)

Он /малын төрөл	2015	2016	2017	2018	2019
Адуу	580	740	900	1000	1160
Үхэр	110	120	170	160	160
Тэмээ	1250	1380	1500	1580	1650
Хонь	2420	2820	3460	3230	3610
Ямаа	36000	40720	49200	48800	55350
Нийт	40360	45780	55230	54770	61930

2.6.2 Уур амьсгалын өөрчлөлт-ган, зуд

Хамгийн өндөр оноо авсан аюул дарамт нь ган, зуд юм. Ган, зудын давтамж ойртсон нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэж үзэж байна.

БНГ нь өвөлдөө хүйтэн, хуурай байдаг бөгөөд зарим тохиолдолд -40С градус хүртэл хүйтэрдэг. Зундаа мөн л хуурай бөгөөд +35С градус хүртэл халдаг. Бороо хур зөвхөн зуны саруудад л ордог (Батжаргал 1997). Жилээс жилд зуны улирал богиносж байгаа (60-120 хоног үргэлжилдэг) бөгөөд ан амьтад ихэнхидээ өнжсөн ургамлаар хооллож байна (Цэрэндаш ба Эрдэнэбаатар 1993).

Говийн бүсийн уур амьсгалын өөрчлөлтөд хийсэн судалгаагаар, жилийн хур тунадас багасч, дулаарал явагдаж байгаа нь тогтоогджээ (Гэрлээ нар., 2017). Хур тунадасны өөрчлөлтийн коэффициент >33% хувьтай байгаа бөгөөд Говийн бүс нь хуурайвтар, тэнцвэргүй ангилалд багтаж байна. (Сулливан ба Рөүд, 2002). Өөрөөр хэлбэл, мал ба бэлчээрийн ургамлын харьцаанд цаг уурын хүчин зүйл чухал нөлөө үзүүлж байна (Иллюс ба О'Коннор, 1999). Тус бүс нутаг нь хур тунадас багатай, ургамлын нөхөн төлжилт муу, хувирамтгай цаг агаартай аж (Аддисон нар., 2012).

Үүнээс гадна, Монгол орны өмнөд говийн уур амьсгалын өөрчлөлт нь хүний аж амьдралд нөлөөлж байна (Ангерер нар., 2008; де Шербин, А 2014). Агаарын хэм 2С градусаар нэмэгдэж (Нандинцэцэг нар., 2007), хүчтэй ширүүн бороо ордог болсон (Гоулден нар., 2016) нь ногоочдод хүндээр тусч байгаа бөгөөд шим тэжээлтэй арвин ургац хураахад сөргөөр нөлөөлж байна (Хишигбаяр нар., 2015). ДНБ-ний гуравны нэгийг ХАА, МАА-с бүрдүүлдэг Монгол орны хувьд, уур амьсгалын өөрчлөлт нь

эдийн засаг, иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөтэй аж (Махул ба Скийс, 2007). Ихэнхи өрхийн амьжиргааны гол эх үүсвэр нь МАА бөгөөд тэд бэлчээрийн ургамал, цаг уурын таатай нөхцлөөс хамааралтай амьдардаг (Батжаргал ба Энхжаргал, 2013) байна. Тиймээс Өмнөговийн уур амьсгалын өөрчлөлт нь малчдын амьжиргаа, уламжлалт мал маллагаанд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд харин ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөө ажиглагдахгүй байна (Мижиддорж 2019).

БНГ-т амьдарч байгаа малчидтай хийсэн ярилцлага, судалгааны дүнгээс харахад, сүүлийн 20 жилд өвөлдөө хүйтний эрч эрс чангарч, цас орох нь багассан бол зундаа хур тунадас бага, гандуу бөгөөд хааяа хувингаар цутгах мэт хүчтэй бороо ордог болжээ (Мижиддорж 2019). Үүнээс болж бэлчээрийн нөөц улам хумигдаж байна. Шим тэжээлгүй өвс ургамал идсэн мал тарга тэвээрэг муутай байх бөгөөд энэ нь малчдын амьдрал амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

Өвлийн цагт цас нь ундны усны гол эх үүсвэр юм. Цас багатай өвөл малчид өвөлжөөндөө буудаггүй бөгөөд өөр газарруу нүүдэг байна. Цас нь зэрлэг туруутнуудад ч мөн ялгаагүй ундны усны гол эх үүсвэр болдог. 2014-2015 оны өвөл цас ороогүйгээс болж тус БНГ-т янгир гэх мэт зэрлэг туруутнууд хэдэн зуугаараа цангаж үхжээ (нутгийн иргэн Доржийн ажиглалт).

Зарим нэг газруудад уур амьсгалын өөрчлөлтөөс болж ган, зудын давтамж ойртох хандлага ажиглагдаж байна (Хавстад, 2008). Малчдад тулгардаг хамгийн том бэрхшээл нь ган, зуд бөгөөд үүнээс болж малчид амьдралын хэв маягаа өөрчилж орлого олох өөр арга зам хайдаг болжээ (Мижиддорж 2019).


Дэд бүтэц, уул уурхай зэрэг хүний нөлөөнөөс болж өөрчлөгдөж буй хүрээлэн буй орчны өөрчлөлт нь урьд урьдынхаас илүү сөргөөр нөлөөлж байна. Хэд хэдэн судалгааны (Луо, Жианг ба Танг, 2015; Бүүвэйбаатар нар., 2016) дүнгээс харахад,

зэрлэг туруутны тархац улам хумигдах хандлагатай байна. Энэ чиг хандлага нь Тост, Тосонбумбын нурууны БНГ-т ч түгээмэл байх магадлалтай тул тус БНГ-т цаг уур, хүрээлэн буй орчны нөлөөллийн мониторинг судалгааг үргэлжлүүлэн хийсээр байна.

2.6.3 Усны хомсдол

Тус БНГ-т жижиг гол, горхиос өөр усны эх үүсвэр байдаггүй (Газрын зураг 6). Зуны цагт ихэнхи усны ундаргууд хатаж цөөн хэдэн горхиноос зэрлэг амьтад ундаалдаг. Жилдээ хоёр удаа, хавар цас хайлсаны

дараа, зун, намартаа бороо орсны дараа усны түвшин ихэсдэг (Ш.Цэгмэд 1969). Хуршуутын баянбүрд, Хайлаастын хөндий, Зулганайн гол зэрэг 17 усны сав газартай гэсэн судалгаа байна.



Газрын зураг 6. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын уст цэгүүд

Худгийг албан ёсоор өмчлөөгүй боловч өрхийн хэрэгцээний эзэмшил газарт байгаа худгууд тухайн өрхийн өмч мэт болдог (Фернандез-Жименез ба Батбуян 2004). БНГ-т 282 худаг байдаг гэсэн тооцоолол байгаа бөгөөд энэ нь 2015 оныхтой харьцуулбал (Тост баг 120 худагтай байсан) хоёрдахин нэмэгджээ ($43^{\circ}20'61''$, $100^{\circ}62'29''$). Гэхдээ эдгээрээс бүрэн ажиллагаатай нь цөөхөн (ИХС, 2015). БНГ-ын малчин өрхүүд жилийн турш гол горхи, худаг усны ойр буудалладаг. Усны эх үүсвэрийн одоогийн нөхцөл байдал нь БНГ-т бэлчээрлэх малын тоо толгойг барих хүчин зүйл болж байна. (Зара Моррис-Трэйнон 2019).

Малчин өрхүүд нэг нутагт бэлчээр


сэлгэлгүй удаан хугацаагаар суурьшиж талхалсны дараа өөр газар руу нүүдэллэх хандлагатай байна. Гурвантэс суманд хийсэн саяханы судалгаагаар, ярилцлага өгсөн малчдын тал гаруй хувь нь жилдээ хоёр удаа 6 сарын зайтай нүүдэллэдэг (зусландаа 4 сараас 8 сар хүртэл, өвөлжөөндөө 10 сараас 3 сар хүртэл буудаг), 30% нь нэг газраа суурин байдаг, 15% нь жилд дөрвөн удаа нүүдэллэдэг гэжээ (Цэрэннадмид нар., 2018).

Тостын нурууны зүүн хэсгээр Гурвантэс сумын төв рүү дөхөж айлууд хоорондоо ойрхон буусан, нягтшил өндөртэй байна (5км^2 талбайд нилээн олон айл буужээ) (Газрын зураг 7). Ус, ногоотой газар ялангуяа

ган гачиг тохиолдсон үед айлууд битүү шавж буудаг гэж ихэнхи малчид (97%) ярьж байна.

Зах зээлийн системд шилжсэн үеэс хойш малчдын уламжлалт мал маллагааны арга их өөрчлөгдсөн. Тухайлбал, малчид нүүдэллэхээ больсон, малын тоо толгой ялангуяа ямааны тоо толгой өссөн, төв суурин газар болон уст цэгийн ойр олноор буудаллаж амьдрах болсон, бэлчээрийн маргаан их гарах болсон. Цөөн тооны усны эх үүсвэрээс хамаарч бэлчээрийг зүй зохисгүй хэрэглэж байгаа нь өнөөдөр тулгарч буй гол асуудал болж байна. Энэ янзаараа үргэлжилбэл яваандаа ноолуурын хангамж, ноолуурын чанар муудах, зэрлэг туруутнууд бэлчээрээ алдах аюул нүүрлэж байна (Зара Моррис-Трэйноор 2019). Гурвантэс сумын

бэлчээрийн бүтцийн 56.2% сөөгт бэлчээр, 20.4% сайр, 22.7% загт бэлчээр эзэлж байна (Сумын захиргааны тайлан, 2016). 2016 оны бэлчээрийн төлөв байдлын үнэлгээгээр Тостын нурууны 15,700 га бэлчээр “их доройтсон”, 43960 га бэлчээр буюу нийт бэлчээрийн 7.3% нь “дунд зэрэг доройтсон” гэсэн дүгнэлт гарчээ (Өсөх Зоос ХХК 2016). Малчин өрхүүд нүүдэллэхээ больсон нь бэлчээр болон усны нөөц хомс байгаатай холбоотой аж. БНГ-т айл буугаагүй уст цэг бараг ховор байна (Зара Моррис-Трэйноор 2019). Усалгааны системтэй ногооны талбайгаас жилдээ 60.0 тонн тэжээл бэлдэж авдаг. Хахир зудтай өвөл тэжээл хүрэлцдэггүй бөгөөд улсаас тэжээл өгөх эсвэл өөрсдөө нэмж худалдаж авдаг байна.



Газрын зураг 7. Тост, Тосонбумбын нурууны БНГ-т сүүлийн 5 жилд намаржаа өвөлжөөний газраа сэлгэлгүй ашигласан айлуудын тоо (n=82)

2.6.4 Туруутан амьтдын бэлчээрийн хомсдол

2015-2019 онд малын тоо толгой 53%-иар өссөн (ҮСХ 2019, Хүснэгт 3). Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын байгаль хамгаалагчдын дүгнэлтээр бэлчээрийн хомсдлоос болж зэрлэг туруутан, хүн хоорондын зөрчил гарч байгаа нь БНГ-т тулгарч буй гол асуудал болоод байна (Дэлгэрэнгүйг 11-р нүүрнээс үзнэ үү).

2.6.5 Хуулийн хэрэгжилт хангалтгүй байдал

Тост, Тосонбумбын нурууг шинээр тусгай хамгаалалтанд авсан тул хүний нөөц бүрдүүлэх, чадавхижуулах, БНГ-ын тухай олон нийтэд мэдүүлж таниулах гээд бүхнийг тэгээс эхэлсэн. Орон нутгийн хязгаарлагдмал төсвөөр үйл ажиллагаагаа явуулдаг тул ямагт нөөц бололцоогоо дайчлан ажиллахгүй бол хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлтэй.

2.6.6 Ашигт малтмалын хайгуул ба олборлолт

Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын гадна талд уул уурхайн компаниуд идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд БНГ дотор хууль бус олборлолт хийх явдал гарч байна (ялангуяа Нэмэгт ууланд хууль бус олборлолт их хийгдэж байна). Нинжа нар болон хууль бус олборлолтын цар


хүрээ хэр их байгааг (Төр эсвэл бие даасан байгууллага) судлах нь зүйтэй. 2011 онд Тост, Тосонбумбын нурууг хамгаалалтанд авахаас өмнө уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас болж цоохор ирвэсний идэш тэжээл цөөрч, амьдрах орчин нь хумигдах маш том аюул нүүрлээд байсан билээ.

2.7 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ


ОУИХС/ИХС ТББ-ын эрдэм шинжилгээний баг оролцогч талуудтай хамтран Тост, Тосонбумбын БНГ-т нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, байгаль орчин, биологийн нөхцөл байдал нь эдийн засаг, улс төр, нийгмийн хүчин зүйлсээс хэрхэн хамаарч байгаа, БНГ-ын үнэт зүйлсийг үр дүнтэй хамгаалахад ямар хүчин зүйлс чухал зэргийг олж мэдэхийг зорьсон.

Ингэхдээ, тус БНГ-т учирч буй аюул дарамтын нарийвчилсан үнэлгээг (Хүснэгт 2) үнэт зүйлс нэг бүр дээр хийж боловсруулсан. Нөхцөл байдлын дүн шинжилгээнд (Диаграм 1) хүчин зүйлс хоорондын харилцаа хамаарлыг харуулсан бөгөөд зорилтот төрөл зүйлийг хамгаалах стратегиудыг тодорхойлсон болно.

Диаграм 1. Тост, Тосонбумбын нурууны БНГ-ын нөхцөл байдлын үнэлгээ



Диаграм 2. Үр дүнгийн гинжин хэлхээний диаграм



2.8 СТРАТЕГИ, ЗОРИЛТ

Хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтад үнэлгээ өгч, тэдгээрийг үүсгэж байгаа шалтгаануудыг тодорхойлсоноор (Диаграм 2) аюул, дарамтын нөлөөг бууруулахад чиглэсэн дараах 5 стратегийг

боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах зорилго бүхий 13 зорилтыг дэвшүүлэн, зорилтуудад хүрэхэд үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай 89 багц үйл ажиллагааг төлөвлөв (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Үйл ажиллагааны стратеги, зорилтууд

